



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2019 оны 04 сарын 12 өдөр

Дугаар 104

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад  
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Сангийн яамны харьяа “Хөдөө аж ахуйн давхар даатгал” хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 50,402,860.20 (тавин сая дөрвөн зуун хоёр мянга найман зуун жаран төгрөг хорин мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг “Тогтвортой амьжиргаа-3” төсөлд балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Наранцогтод дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ


Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

0000231

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2019 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн  
10 дугаар тогтоолын хавсралт



“Хөдөө аж ахуйн давхар даатгал” хувьцаат компаниас  
“Тогтвортой амьжиргаа-3” төсөлд балансаас  
балансад шилжүүлэх автомашин

Д/д	Автомашины марк, улсын дугаар, арал	Үйлдвэрлэсэн, ашилгалаад орсон он	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Ландкрузейр-105, 02-42 УБЛ, арал № JTJECJ091- 10550765	2005/ 2005	50,402,860.20	50,402,860.20	0
	Нийт дүн		50,402,860.20 (тавин сая дөрвөн зуун хоёр мянга найман зуун жаран төгрөг хорин мөнгө)	50,402,860.20 (тавин сая дөрвөн зуун хоёр мянга найман зуун жаран төгрөг хорин мөнгө)	0